



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/218

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталасан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын бахархал, үнэт зүйл болсон Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн байлдааны тугийг тус аймагт хүлээн авч, аялуулах, ёслолын жагсаал, арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

А.Алтанцоож -Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

Гишүүдэд:

С.Батхуяг-Цэргийн штабын дарга, хурандаа

Ё.Пүрэвсүрэн-Онцгой байдлын газрын дарга,
Хурандаа

Б.Эрдэнэбат-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын
дарга, хурандаа

С.Мөнхбаатар-Шүүхийн шинжилгээний албаны дарга,
цагдаагийн хошууч

Б.Баасансүрэн-Хилийн цэргийн 0257 дугаар ангийн
Захирагч, хурандаа

Ч.Бумцэнд- Зэвсэгт хүчний 321 дүгээр тусгай
салбарын захирагч, ахмад

Нарийн бичгийн

дарга:

Б.Алтанцог- Нийтийн хэв журам хамгаалах тасгийн
дарга, цагдаагийн хошууч

2. Цагдаа, дотоодын цэргийн байлдааны тугийг залж, аялуулах, хүндэтгэл үзүүлэх, ёслолын жагсаал, үйл ажиллагаанд шаардлагатай зохих зардлыг

671 010073

2. Цагдаа, дотоодын цэргийн байлдааны тугийг залж, аялуулах, хүндэтгэл үзүүлэх, ёслолын жагсаал, үйл ажиллагаанд шаардлагатай зохих зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН